



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 48


Сүхбаатар сум


Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1."Залууст боломж" аймгийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, нэгдсэн удирдлагаар хангах, хөтөлбөрийн явцыг 2 жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д даалгасугай.

ДАРГА  Т.БЯМБАА



“ЗАЛУУСТ БОЛОМЖ” олгож, дэмжих аймгийн хөтөлбөр

Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Өсвөр үе, залуучуудын асуудлаар хууль эрх зүйн орчин сайжирч байгаа ч эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлж, тэдэнд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсролын чанарт анхаарч залуучуудын өрсөлдөх чадварыг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгэм дэх оролцоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүүхэд, өсвөр үе, залуучуудын асуудал, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг хөтөлбөрүүдийн бодлого, зорилттой “Залууст боломж” хөтөлбөр уялдан хэрэгжинэ.

Сэлэнгэ аймгийн нийт 108768 хүн амын 6884 буюу 6.3 хувийг 15-18 өсвөр насны хүүхдүүд, 35517 буюу 32.6 хувийг 15-34 насны залуучууд үүнээс: 19402 буюу 54.6 хувийг 15-34 насны эрэгтэй, 16115 буюу 45.4 хувийг эмэгтэйчүүд тус тус эзэлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн байдлаар 2017 онд аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 824 болсон байна.

Нийт ажилгүйчүүдийн 43.7 хувийг ерөнхий боловсролтой, 35 хувийг дээд боловсролтой, 13.1 хувийг мэргэжилтэй ажилчид, 7.5 хувийг тусгай дунд боловсролтой, 0,7 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна

Залуучуудын дундах өвчлөл сүүлийн жилүүдэд нэмэгдэж, 18-30 насны залуучууд гэмт хэрэгт холбогдох явдал тууштай буураагүй зэрэг олон асуудлыг цогцоор шийдвэрлэх зорилгоор “Залууст боломж” олгож, дэмжих хөтөлбөрийг боловсруулсан болно.

Нэг.Хөтөлбөрийн зорилго

Өсвөр үе, залуучуудыг бие даах чадвар болон амьдрах ухаанд сургаж, хөдөлмөр эрхлэх нөхцөл, ажлын байраар хангах, тэдний нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэн, зохих түвшинд шийдвэрлэх, энэ талаарх санал, санаачлагыг урамшуулан дэмжиж, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэхэд оршино.

Хоёр. Хөтөлбөрийн зорилт

- 2.1.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажлын байраар хангах
- 2.2.Өсвөр үе, залуучуудад эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлж, тэдэнд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх
- 2.3.Боловсролын чанарт анхаарч, залуучуудын өрсөлдөх чадварыг сайжруулах
- 2.4.Залуучуудын нийгмийн оролцоо, хөгжил, хамгааллын үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдлыг хангах

Гурав.Хөтөлбөрийн хамрах хүрээ

- 3.1.Залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хамаарна.

Дөрөв. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа

4.1. Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

- Нэгдүгээр үе шат: 2018 - 2020 он

- Хоёрдугаар үе шат: 2020 – 2022 он

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтын хүрээнд:

5.1.1. Их дээд сургууль, коллеж, мэргэжлийн чиг баримжаа олгох, сургууль төгссөн залуучуудад ажлын байранд холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх, ажлын байраар хангасан аж ахуй нэгжүүдийг идэвхижүүлэн урамшуулах

5.1.2. Нийгмийн дэмжлэг туслалцаа шаардлагатай залуучуудад үзүүлэх сайн дурын ажлыг хөхиүлэн дэмжих

5.1.3. Залуучуудын гарааны бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, сургалтанд хамруулах, “Гарааны бизнес” –ийг дэмжих төв байгуулах

5.1.4. Бизнес инкубатор төв байгуулж, жижиг дунд үйлдвэр, бичил бизнес эрхэлж буй залуу гэр бүлийг дэмжих, үйл ажиллагааг нь сурталчлах

5.2. Залуучуудад эрүүл амьдрах зан үйлийг төлөвшүүлж, тэдэнд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

5.2.1. Өсвөр үе, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл амьдралын хэв маягт сургах нөлөөллийн ажил зохион байгуулах

5.2.2. Дэлгэцийн донтолт, архи, тамхи, мансууруулах бодисын хор нөлөө, хүчирхийлэл, дарамт, шахалт, эрсдэлд өртөхөөс сэргийлэх талаар хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах

5.2.3. Спортын төрөл бүрийн арга хэмжээг эрүүл амьдрах зан үйлд тулгуурлан зохион байгуулах

5.2.4. Бүс нутгийн онцлогоо ашиглан Эрхүү, Улаан-Үүд, Хиагт хотын болон бусад орны залуучуудын байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага солилцох, найрсаг хамтын ажиллагааг бэхжүүлэх, олон талт арга хэмжээг зохион байгуулах

5.3. Боловсролын чанарт анхаарч, залуучуудын өрсөлдөх чадварыг сайжруулах зорилтын хүрээнд:

5.3.1. Гадаад орнуудад сурч, ажиллаж байгаа залуучуудын чуулга уулзалтыг 2 жил тутам зохион байгуулж тулгамдсан асуудал, санал, санаачлагыг дэмжих, орон нутгийн хөгжил дэвшилд тэдний оролцоог нэмэгдүүлэх

5.3.2. Өсвөр үе, залуучуудыг зөв амьдрах арга ухаанд сургах, гадаад хэл сурах идэвхи санаачлагыг дэмжих, сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах

5.3.3. Оюутан залуучуудад манлайллын ур чадварыг эзэмшүүлэх, эв нэгдэлтэй байх талаар олон талт арга хэмжээг зохион байгуулах

5.3.4. Бичиг үсэг үл мэдэгч залуучууд, насанд хүрэгчдэд бичиг үсгийн боловсрол олгох, дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд хамруулж, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалт зохион байгуулах

5.3.5. Амжилт гаргасан сурагч, оюутан, залуусыг урамшуулан дэмжих, алдаршуулах

5.5. Залуучуудын нийгмийн оролцоо, хөгжил, хамгааллын үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдлыг хангах зорилтын хүрээнд:

5.5.1. Залуучуудын хөгжлийг дэмжих хуулийн хэрэгжилтийг хангах, залуучуудын эрх ашигт нөлөөлөх аливаа асуудлаар шийдвэр гаргах, бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, хянаж үнэлэхэд иргэний нийгмийн байгууллага, залуучуудын оролцоог хангах

5.5.2. Төрөлх хэл, түүх, ёс заншил, уламжлалт соёлоо танин мэдэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, Монгол бахархал ёс заншил,

аймаг орон нутгийн талаар өсвөр үе, залуучуудад ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх мэтгэлцээний клуб байгуулж дэмжин ажиллах

5.5.3.Нийгэм, соёл, улс төр, эдийн засгийн идэвхтэй оролцоог төлөвшүүлж, залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг дэмжих

5.5.4.Аймгийн хэмжээнд “Залуучуудын хөгжлийн төв” байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах

5.5.5.Залуучуудыг гэмт хэрэг, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил зохион байгуулах

5.5.6.Орон байр худалдан авах боломжгүй эсвэл түр хугацаагаар амьдрах хэрэгцээтэй залуучуудад зориулж хямд түрээсийн болон нийтийн байр барих ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхийг дэмжин ажиллах

Зургаа. Хүрэх үр дүн

6.1.Ажилгүйдэлд залуучуудын эзлэх хувь багасна.

6.2.Эрүүл зан үйл, дадал хэвшил эзэмшиж, тэдэнд ээлтэй хөгжлийн орчин бүрдэнэ.

6.3.Залуучуудын нийгэмд оролцох оролцоо нэмэгдэнэ.

6.4.Залуучуудыг соён гэгээрүүлэх, тэдэнд чиглэсэн хөгжлийн үйлчилгээ нэмэгдэнэ.

6.5.Залуучуудын хөрөнгө санхүүгийн мэдлэг дээшилж, амьдрах чадавхи бэхжинэ.

Долоо.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт

7.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх.

7.2.Гадаад, дотоодын төсөл хөтөлбөрөөс олгох тусламж, дэмжлэг.

Найм.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгжилтийг тайлагнах /хяналт шинжилгээ үнэлгээ/

8.1.Залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллана.

8.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, шаардлагатай төсвийг жил бүр боловсруулан батлуулж, мэргэжил, арга зүй, удирдамжаар хангах үүргийг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хариуцах бөгөөд хэрэгжилтийн явцыг хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын зөвлөлд тайлагнана.